“Улаанбаатар хотын даатгал” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 02 сарын 08-ны өдрийн 1-3/01 тоот
тогтоолын Хавсралт №01



ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Улаанбаатар хотын даатгал”ХХК-ийн /цаашид “Компани” гэх/ үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах, удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүй суларснаас үүдэн хөрөнгө оруулагчид, оролцогч талууд хохирохгүй байх нөхцөлийг хангахын тулд залгамж халааг бэлтгэн төлөвлөнө.

1.2. Энэхүү бодлогын баримт бичгийн зорилго нь ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний залгамж халааг төлөвлөхөд оршино.

Хоёр. Залгамж халааг бэлтгэх журам

2.1. ТУЗ болон удирдах албан тушаалтнуудын залгамж халааны төлөвлөгөө

2.1.1. ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүн, удирдах албан тушаалд тохирох хүнийг хэлэлцүүлж тодорхойлно.

2.1.2. ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүн эсвэл компанийн удирдах албан тушаалд шинээр буюу улираан нэр дэвшүүлэхээр эсвэл томилохоор төлөвлөж буй хүн тус бүрийн тухайн албан тушаалд тохирох эсэхийг боловсрол, туршлага, гаргасан амжилтыг нь нягтлан шалгасны үндсэн дээр тодорхойлно.

2.1.3. ТУЗ-ийн хурлаар ТУЗ-ийн гишүүн эсвэл компанийн удирдах албан тушаалд шинээр буюу улираан нэр дэвшүүлэхээр томилох, чөлөөлөх саналыг ТУЗ-өөс гаргана. Ийнхүү нэр дэвшүүлэхээр томилох, чөлөөлөхөд Компанийн тухай хууль болон компанид хамаарах бусад хууль тогтоомж, дүрэм журмын холбогдох зүйл, заалтуудыг мөрдлөг болгоно.

2.2. Гүйцэтгэх удирдлагын багын залгамж халааны төлөвлөгөө

2.2.1. ТУЗ нь гүйцэтгэх захирлын хамтаар гүйцэтгэх удирдлагын багын гишүүдээс тухайн жилд тэтгэвэрт гарах эсвэл чөлөөлөгдөх хүсэлтэй хүн байгаа эсэхийг тодорхой давтамжтайгаар нягталж хяналт тавина. Бизнесийн хэрэгцээ шаардлага болон газар албадыг өргөтгөхтэй холбогдуулан шинээр гарч болзошгүй орон тоог гүйцэтгэх захиралд санал болгож, ТУЗ-ийн шийдвэрээр батална.

2.2.2. Гүйцэтгэх удирдлагын баг доторх чөлөөтэй орон тоо, томилгооны асуудлыг байгууллагын эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйл, зорилго, зорилттой уялдуулна.

2.2.3. Гүйцэтгэх захирал нь хүний нөөцийн чиг үүргийн тусламжтайгаар албан тушаал дэвшин ажиллах чадварлаг ажилтнуудыг тодорхойлох ба санал болгох, ур чадварыг нь хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах ба хэрэгжүүлэх, хяналт тавих ба үнэлж дүгнэх, тухайн ажилтнуудад шаардлагатай сургалтын хэрэгцээг тодорхойлон ажиллах зэргийг хариуцах ба ТУЗ-өөс шаардлагатай дэмжлэг туслалцаагаар хангана.

2.2.4. ТУЗ-өөс компанийн тодорхой чиг үүргийг удирдан ажиллах чадварлаг ажилтнуудыг олж тогтоох, хөгжүүлэхэд чиглэсэн дотоод бодлого, журмуудыг боловсруулах эрхийг олгож болно.

Гурав. Гэнэтийн тохиолдолд авах арга хэмжээ буюу түр томилгоо

3.1 ТУЗ-ийн гишүүн эсвэл удирдах албан тушаалтан нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо чөлөөлөгдөх тохиолдолд ТУЗ яаралтай орлох этгээдийг тодорхойлон, хууль тогтоомжийн дагуу томилгоог албажуулна.

3.2 Гүйцэтгэх удирдлагын багын гишүүн нас барсан, өөр бусад гэнэтийн шалтгааны улмаас орон тоо нь чөлөөлөгдсөн тохиолдолд гүйцэтгэх захирал ТУЗ-тэй зөвшилцөн орлох этгээдийг томилно.

3.3 Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтан урт хугацаанд өвчтэй эсвэл чөлөөтэй байх үед түүний ажил үүргийг гүйцэтгэн орлох этгээдийг гүйцэтгэх захирал томилно. ТУЗ тухайн ажилтныг тухайн ажил үүргийг гүйцэтгэж чадахгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухай гүйцэтгэх захиралтай зөвшилцөн, томилгоог өөрчилж болно.

Дөрөв. Хяналт сайжруулалт

4.1. Энэхүү бодлого нь холбогдох журмуудын хэрэгжилтэд ТУЗ хяналт тавьж ажиллах ба бодлогын баримт бичгийн гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, түүнийг дагалдах залгамж халааны төлөвлөгөө үр дүнтэй хэрэгжиж буй эсэхийг хянах зорилгоор үнэлэлт дүгнэлт өгнө.

4.2. ТУЗ энэхүү бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхтэй холбогдсон асуулт байвал холбогдох этгээдээс тодруулга авах, аливаа асуудал гарвал засаж залруулах бүрэн эрхтэй байна.

4.3. Холбогдох эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагын дагуу уг бодлогод нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

Тав. Бодлогын талаар нийтэд мэдээлэл хүргэх тухай

5.1. Компанийн тухай хууль, түүний хүрээнд батлагдсан журмууд, Санхүүгийн зохицуулах хорооны баталсан дүрэм, журам, тэдгээрийн шинэчилсэн хувилбар болон бусад хууль журмаар шаардсан тохиолдолд энэхүү бодлогын талаах мэдээллийг компанийн жилийн тайланд оруулж, бодлогын баримт бичгийг цахим хуудсанд байршуулна.